



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.14 № 3/421
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгад аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн тайлан, түүний тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



**ДУЛААНЫ 2 ДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
Т.Ө.Х.КОМПАНИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

**САГ-ын дарга, тэргүүлэх
аудитор:** Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг:

naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер:

Я.Самбууням

Утас: 260512

Цахим хаяг:

sambuunyamy@audit.gov.mn

Ахлах аудитор :

Д.Ганбилэг

Утас: 261885

Дундманхайдай аудит ХХК

аудитор: Ж.Бямбажав

Д.Төмөрбаатар

Н.Тэмүүжин

Хавсралт 1: Агуулга /ТАБ-СТА-С-2/

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ/ТАБ-СТА-С-1/

Хавсралт 3: Менежментийн захидал /ТАБ-СТА-С-3/

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Санхүүгийн тайлангийн тодруулга.

1. Оршил
2. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
3. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
4. Байгууллагын зорилго,үйл ажиллагаа
5. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
6. Дотоод хяналт
7. Орлого, зардлын төлөвлөгөөний биелэлт, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын зөвлөмж, дүгнэлт
18. Менежментийн захидал
19. Аудитын гэрчилгээ
20. Аудитлагдсан санхүүгийн тайлан
21. Санхүүгийн тайлангийн тодруулга

1. Оршил

Үндэсний аудитын газартай байгуулсан гэрээг үндэслэн “Дундманхайдай аудит” ХХК нь “Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж тайлангийн дүгнэлтийг “Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлага болон Үндэсний аудитын газарт танилцуулж байна.

Менежментийн захидалд санхүүгийн дотоод хяналтын журмыг сайжруулах талаархи бидний зөвлөмжүүдэд Дулааны 2 дугаар цахилгаан станц ТӨХК-ийн удирдлага, санхүүгийн ажилтнуудын саналыг солилцон тусгасан болно.

2. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалт, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх хэсэг, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2013 оны 158 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх журам”-ын 2.7-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ /САГ/2017/6-СТА-ГАК-ТӨХК / аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /НББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК нь санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2012 оны 77 тоот тушаалаар батласан “Аж ахуйн нэгжид мөрдөх санхүүгийн тайлан, түүний тодруулгыг бэлтгэх заавар”, Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт /СТОУС/-ын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн явцын аудитыг 2016 оны 11 дүгээр сарын 25-наас 2016 оны 12

дугаар сарын 15-ны хооронд, гүйцэтгэлийн аудитыг 2017 оны 1-р сарын 30 наас 3-р сарын 5-ны хооронд зохион байгуулан “Дундманхайдай аудит” ХХК-ны аудитор Ж.Бямбажав, Д.Төмөрбаатар, Н.Тэмүүжин, аудиторын туслах С.Ариунтунгалаг нар хэрэгжүүлэв.

“Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 21-нд “Дундманхайдай аудит” ХХК -д ирүүлсэн байна.

“Дундманхайдай аудит” ХХК нь аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 6-нд Санхүүгийн аудитын газраар хянуулан тайлан, дүгнэлтийг баталгаажуулан 2017 оны 3 сарын 10-ны дотор “Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захиралд гардуулна.

3. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь Монгол Улсын “Компанийн тухай”, “Эрчим хүчний тухай”, “Цахилгаан дулааны эрчим хүч, нүүрсний төлбөрийн тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Галын аюулгүй байдлын тухай”, “Гамшгаас хамгаалах тухай”, “Усны тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай”, “Эрчим хүч хэмнэлтийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Шилэн дансны тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай”, “Нийгмийн даатгалын тухай”, “ХХОАТатварын тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэж байна. Тайлант хугацаанд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй ч, НББ-ийн тухай хууль шинээр хэрэгжсэн байна.

4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК нь 1961 онд ТС-35-39 маркийн ул ширэмтэй 3 зуух, АК-6 маркийн 2 турбингенератортай 12 мВт –ын суурилагдсан хүчин чадалтайгаар баригдаж, Толгойтын цахилгаан станц нэртэйгээр ашиглалтанд орсон ба 1969 онд өргөтгөл хийж өнөөдрийн байдлаар тус станц нь БКЗ-75-39фб маркийн 2 зуух, ТС-35-39 маркийн 2 зуух, АК-6, Р-4, ПТ-12-35/10 маркийн 3 турбингенератортай 21.5 мВт –ын суурилагдсан хүчин чадалтайгаар ажиллаж байна. Цахилгаан эрчим хүчний суурилагдсан хүчин чадал ашиглалт 60.0 гаруй хувьтай, усаар түгээх дулааны хүчин чадал ашиглалт 70.0 гаруй хувьтай байна.

Монгол Улсын засгийн газрын 2001 оны 7 сарын 9-ний өдрийн 164 дүгээр тогтоолоор 100 хувийн төрийн өмчит хувьцаат компани болгон зохион байгуулагдсан байна. Компаний 41 хувийг Эрчим хүчний яам, 39 хувийг ТӨХ, 20 хувийг Сангийн яам эзэмшдэг. Монгол Улсын “Эрчим хүчний тухай” хуулийн дагуу 3 төрлийн тусгай зөвшөөрөл аван ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10 тэрбум төгрөгийн өртөгтэй ажил хийгджээ. Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын үр дүнд: Тус станц дээрээс 16 фидерээр нийт 115 хэрэглэгч, айл өрхийг хангах дэд станцууд шууд тэжээгдэж байдаг нь тус станцын 6кВ, 35 кВ –н хуваарилах байгууламжийн шинэчлэлийн дүнд хэрэглэгчийн цахилгаан хангамжийн найдвартай байдал дээшилсэн. Хэрэглэгчийг дулаанаар хангах гол

тоноглол болох ПТ-12-10/М турбины тохируулгын систем сайжирч станцын горим ажиллагаанд эерэгээр нөлөөлж дулаанжуулалтын тоноглолын найдвартай ажиллагаа хангагдсан байна.

2016 онд 17 043.4 сая төгрөгийн цахилгаан эрчим хүчний, 2 147.0 сая төгрөгийн дулаан эрчим хүчний, 159.4 сая төгрөгийн үндсэн бус үйл ажиллагааны борлуулалт тус тус хийсэн байна. Тàééáíâëéí ðóããðàãáíá станц 8640 ц ажиллаж цахилгааны дундаж ачаалал 17,9 мвт/ц-д хүрч өмнөх оноос 0,94 мвт/ц-аар нэмэгдсэнээр жилдээ 154492.3 мян квт ц ЦЭХ боловсруулсан бөгөөд 132826.6 мян квт ц ЦЭХ түгээсэн нь анхны төлөвлөгөөнөөс 1264.6 мян квт ц-аар илүү буюу 101.0% биелсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал 5661,6 мян квт ц эрчим хүч буюу 4,5%-иар илүү түгээсэн байна.

ЦЭХ-ний түгээлтийн бүтцийг харвал: 97.0% буюу 128807.1 мян квт ц –ийг ЦДҮС ХК-нд түгээсэн байна. Шиний өөрийн хэрэглэгчдэд 3224 мян квт ц буюу 2.4%, станцын өөрийн хэрэглээнд 795.6 мян квт ц буюу 0.6% тус тус түгээсэн байна.

Усаар 166345 Гкал, уураар 18426 Гкал, нийт 184771 Гкал ДЭХ түгээсэн нь анхны төлөвлөгөөнөөс 1651 Гкал илүү буюу 101%, диспетчерийн графикайн зөрчилгүй ГОТ 100 % биелсэн. Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 7617 Гкал дулаан их түгээж 104,3 %-н биелэлттэй түгээсэн байна.

“Дулааны 2 дугаар цахилгаан станц”-ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

5. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс гүйцэтгэх удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд бүртгэлийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 19-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоолоор санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулсныг мөрдөн ажиллахыг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосон байна. Ординат ХХК-ний ”Веница” програмыг хэрэглэж байна.

Уг програм нь Санхүүгийн тайлагналын Олон Улсын стандарт болон Монгол улсын НББ-ийн стандартад нийцсэн 2015 оны сүүлээс эхлэн сайжруулалт хийлгэн ажиллаж байна.

а. Тайлагналын суурь

Дулааны 2 дугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2016 оны нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан бэлтгэлт нь Монгол Улсын Санхүү, Эдийн Засгийн Яамнаас батлан гаргасан сайдын 2000 оны 116 дугаар тушаал, “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн заавар”, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэж заавар”-д нийцсэн байна. Энэхүү тайлагналын суурь нь үндсэндээ Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад заасан аккрузл суурьтай нийцэх юм.

б. Тайлагнасан валют

Компанийн данс бүртгэл нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр хөтлөгддөг ба санхүүгийн тайланг төгрөгөөр бэлтгэжээ. Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн хугацаанд Монгол банкнаас зарласан албан ханшаар хөрвүүлж, төгрөгөөр бүртгэдэг.

в. Санхүүгийн хэрэгслүүд

Компани нь хувьцаа, авлагын болон өрийн бичиг зэрэг санхүүгийн хэрэгслүүдийг гаргаж, нийтэд арилжаагүй болно.

Тайлангийн хугацаанд банкны харилцах дансны гүйлгээний санхүүгийн баримтанд нэгдүгээр гарын үсгийг Гүйцэтгэх захирал М.Баянмөнх, С.Бямбахүү, хоёрдугаар гарын үсгийг санхүү хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Б. Гоёцэцэг, С.Одбаяр нар зурж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

“Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд энгийн буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программ хэрэглэн Сангийн сайдын 2012 оны 77 тоот тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжид мөрдөх санхүүгийн тайлан, түүний тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу тайлагнасан байна.

6. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна. 2016 онд Хяналтын хэлтсийн ажлын төлөвлөгөөний дагуу санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналт шинжилгээ, мэдээ судалгаанд хяналт тавих, бусад хяналт шинжилгээ гэсэн чиглэлүүдээр дотоод хяналт хэрэгжүүлэн ажилласан байна.

7. Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 онд нийт орлогын төлөвлөгөө 17,994,0 сая төгрөгөөр батлагдсанаас, гүйцэтгэлээр 19,190,4 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 106,6 хувиар буюу 1,196,4 сая төгрөгөөр давуулан биелүүлж, зардлын төлөвлөгөө 18,184,0 сая төгрөг, гүйцэтгэлээр

18,714,6 сая төгрөг зарцуулж, төлөвлөгөөнөөс 530,6 сая төгрөгөөр буюу 2,9 хувиар буюу хэтрэлттэй зарцуулсан байна. 2016 онд 190,0 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 475,8 сая төгрөгийн ашигтай ажиллаж, алдагдлыг 665,8 сая төгрөгөөр бууруулсан байна.

2016 онд өмнөх оноос нийт орлого 2,983,0 сая төгрөгөөр, зардал 2695,8 сая төгрөгөөр өссөн ба өмнөх оноос нийт алдагдлын хэмжээ 287,2 сая төгрөгөөр буурсан байна.

2016 онд нийт борлуулалтын өртөг өмнөх оноос 2,056,7 сая төгрөгөөр өссөн ба 2015 онд 188,2 сая төгрөгийн ашигтай ажиллаж байсан бол 2016 онд өмнөх оноос ашгийн хэмжээ 287,6 сая төгрөгөөр өсөж 475,8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

1. Шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайланг жилийн дүнгээр тус бүр нэг удаа оруулан ажилласан бөгөөд харин үр дүн, тайлбарыг хангалттай түвшинд мэдээлээгүй байна.
2. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан тендерийн ерөнхий мэдээллийг 2-11 саруудад оруулан ажилласан байна. Харин концесстэй холбоотой үйл ажиллагаа явагдаагүй тул концессийн тухай мэдээллийн хэсэгт тэмдэглэгээ хийгдээгүй байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 19 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 19 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Байгууллагын батлагдсан зорилтот түвшин түүний гүйцэтгэлийн үр дүн, цалингийн сан түүний гүйцэтгэл, байгууллага хүмүүстэй хийх төлбөр тооцоо, харилцах болон бэлэн мөнгөний дансны гүйлгээ, авлага, өглөг, хөрөнгө материалын бүртгэл тооллого, тооцоо бодолт, худалдан авах үйл ажиллагааны хэрэгжилт, анхан болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт зэргийг холбогдох хууль тогтоомжийн заалтуудтай тулган шалгахад дараах эрсдлүүд илэрсэн болно.

1. Бэлтгэн нийлүүлэгч байгууллагын буюу худалдан авалтын ихэнх хувийг эзэлж буй Багануур ХК-тай тооцоо хийхдээ ачилтын даац хэтэрсэн вагоны буцаалтын акт байхад нүүрс орлогод бүртгэх, пүүлэгч пүүний баримтыг дугаар алгасан бичдэг, вагон пүүлсэн тухай мэдээ, төмөр замын тээврийн хөлсний тооцооны баримтуудын стандартын буюу стандартын бус нүүрсний вагоны тоо зөрөх буюу 2 талын вагоны жинг зөрөхөд нүүрсний илчлэгийн жингээр дундажлан үнийг тооцон нэмж буй зэрэг зөрчлүүд илэрсэн,
2. Бараа материал, хөрөнгийг тавьж олгох, материалын тайлан гаргахад анхан шатны баримтын бүрдэл хангахгүй байх, дансны бичилтийг буруу бүртгэснээс

байгууллагын үр дүнг бууруулах, нөгөө талаас санхүүгийн тайланд хөрөнгө, бараа материалын эхний үлдэгдлүүд буруу илэрхийлсэн,

3. Байгууллагын дансанд бүртгэлтэй хөдлөх буюу үл хөдлөх хөрөнгө түрээслүүлсний орлогын тодорхой хувийг төсөвт төвлөрүүлээгүй
4. Үйл ажиллагааны зардлыг үндэслэлийг нарийн тооцоолоогүйгээр төлөвлөснөөс зарим нэр төрлийн зардал хэтрэлттэй байна.
5. Гүйцэтгэх удирдлагаас аяллын зардлын асуудлаар ТУЗ-ийн шийдвэр гаргуулаагүй байна.
6. “Аморе интернэшнл” ХХК-аас авах авлага зохих хэмжээгээр барагдуулсан ч бүрэн барагдаагүй байна.
7. Зорилтот түвшин, худалдан авах ерөнхий төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бараа ажил үйлчилгээний худалдан авах ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангахгүй байх
8. Шилэн дансны мэдээллийн санд зардлын гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл тайлбарыг бүрэн оруулж тайлагнах асуудал шаардлагын хэмжээнд хүрээгүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр асуудлуудыг аудитаар илэрсэн зөрчлүүд түүнийг шийдвэрлэсэн байдал хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

“Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, үндсэн үйл ажиллагааны болон бусад орлого, бараа материал, тээвэр шатахуун, нүүрс, авлага болон өр төлбөр, цалин хөлс, татвар хураамж зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 90 хувь, мөнгөн хөрөнгийн 85 хувь, бараа материалын 80 хувь, зардлын 60 хувь, авлага, өглөгийн 70 хувь, нийт хөрөнгийн 85 хувийг тус тус эзэлж байна.

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Аудитын явцад байгууллагад илэрсэн зарим зөрчлийг гүйцэтгэх захирал буюу удирдлагын анхааралд хандуулж байна. Эдгээр зөрчлийг захирал, нягтлан бодогч нартай зөвшилцөн санал солилцсон болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Тус компанийн гол эх үүсвэрийг ханган нийлүүлэгч Багануур ХК-ний тооцоог журналын хөтлөлт болон анхан шатны баримтын орлого зарцуулалтыг тулган үзэхэд ачилтын даац хэтэрсэн вагоны буцаалтын акт байхад нүүрс орлогод бүртгэх, пүүлэгч

пүүний баримтыг дугаар алгасан бичдэг, вагон пүүлсэн тухай мэдээ, төмөр замын тээврийн хөлсний тооцооны баримтуудын стандартын буюу стандартын бус нүүрсний вагоны тоо зөрөх буюу 2 талын вагоны жинг зөрөхөд гэрээнд заагдсанаар нүүрсний илчлэгээс хамааран дундаж жингээр үнэлж орлогыг сарын эцэст бөөндөн нүүрс худалдан авч материалын тайланд орлого авсан боловч, зарцуулалтыг гүйцэтгэлээр нь бус шаардах хуудсаар зарлагын зарцуулалтыг тооцдог, жилийн эцсийн санхүүгийн тайланд материалын бодит тооллого тооцоо бодолт хангалтгүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “ бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд “ иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан гэрээнд заагдсан ажил үйлчилгээний өртөг, зардлыг бодитой тооцож хэвших зөвлөмж хүргүүлэв.

2. Бараа материал 16 дэд дансны 14 дансны эхний үлдэгдэл болон зарим үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл зөрүүтэй , 14400, 14110, 14510-10 тоот данснаас 87500-59-0002 тоот дансанд 57,8 сая төгрөгийн зарлагдсан гүйлгээ нь дансны бичилтийг буруу бүртгэснээс байгууллагын үр дүнг бууруулсан нь санхүүгийн тайлангийн оршин байх, үнэн зөв байдал гэсэн аудитын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ерөнхий журналд харилцсан дансны бичилтийн залруулга хийлгэн санхүүгийн тайланд тусгасан.

3. Байгууллагын дансанд бүртгэлтэй хөдлөх буюу үл хөдлөх хөрөнгө түрээслүүлсний орлогын тодорхой хувийг төсөвт төвлөрүүлээгүй Пүүний буюу хөрөнгийн орлогын 24 072 163.27 төгрөгнөөс ТӨБЗГ-т төвлөрүүлэх 20 хувийн орлогыг шилжүүлээгүй зөрчил нь Монгол Улсын төрийн өмчийн хорооны тогтоол 2007 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 42 тоот тогтоолоор “Түрээсийн төлбөрийн доод үнэ, гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай”-ын 3.в “Төрийн өмчит хуулийн эдгээдийн санхүүгийн тайлан балансад бүртгэлтэй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг хуулийн этгээд, иргэдэд түрээслүүлсгадынээс олсон орлогын 20 хувийг төрийн өмчийн хорооны төрийн сангийн дансанд сар бүр төвлөрүүлж, улирал, жилийн эцэст төрийн өмчийн хороотой тооцоо нийлж акт үйлдэж байх” гэж заасантай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Холбогдох тооцоог биечлэн баталгаажуулан 2017 оны эхний улиралд ТӨБЗГ-т 20 хувь буюу 4,814.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх зөвлөмж хүргүүлэв.

4. Үйл ажиллагааны зардлыг үндэслэлгүй төлөвлөснөөс зарим нэр төрлийн зардал хэтрэлттэй байна.Үүнд: Удирдлагын зардал 16,337.8 мянган төгрөг, ажиллагсдын нийгмийн зардал 55,040.7 мянган төгрөг, урсгал засвар- 57,192.2 мянган төгрөг, гадны үйлчилгээний хөлс 32,685.9 мянган төгрөг, зохицуулагчийн үйлчилгээний хөлс 15,558.8 мянган төгрөг, үйл ажиллагааны бусад зардал 137,831.2 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 46.1.4-т “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн тухай хуулийн 62.1.15 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлж байна.

5. Гүйцэтгэх удирдлагаас аяллын зардалд 55,725.0 мянган төгрөгийг зарцуулсан асуудлаар ТУЗ-ийн шийдвэр гаргуулаагүй нь хууль зүйд нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн тухай хуулийн 84.4.3-т “компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлж байна.

6. “Аморе интернэшнл” ХХК-аас авах авлага зохих хэмжээгээр барагдуулсан ч 2012 оны ДЭХ-ний 22,721.2 мянган төгрөг, 2014 оны ажлын хөлс материалын 55,575.7 мянган төгрөгийн авлагууд барагдуулаагүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуй нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ”, гэсэн заалттай нийцээгүй бөгөөд “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах

7. 2016 оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн үр дүнд хийсэн ажлын хүрээнд үндсэн тоноглолын их засвар, үйлчилгээ, худгийн барилгын болон холболтын ажил, автомашин худалдан авах нийт 4 ажлыг гүйцэтгүүлэхдээ Эрчим хүчний яам болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төсөвт өртгийг хэтрүүлсэн 3 ажлын 211,645,9 мянган төгрөгийн, техникийн тодорхойлолт үнийн санал авах баримтгүй, дүгнэлт, протоколгүй 1 ажлын 11,700,0 мянган төгрөгийн ажлуудын төлбөрийг гүйцэтгэсэн зөрчил гаргасан байна./Жагсаалтыг хавсаргав/

Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө”

-4 дүгээр зүйлийн 4.1.2.50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд захиалагч байна.

-46 дугаар зүйлийн 46.1. Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараах эрх, үүрэгтэй байна:

-46.1.4. худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;

-46.1.6. бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих;

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Байгууллагын зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, бараа ажил үйлчилгээг худалдан авах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх

Эдгээр зөрчил нь дараах хуулийн холбогдох заалтууд болон санхүүгийн тайлангийн толилуулгын батламж мэдэгдлүүдийг зөрчсөн байна. Тухайлбал:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцсэн байх”. Мөн хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт

бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7.-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”.
- Иж бүрэн байх: “бүртгэгдээгүй хөрөнгө, өр төлбөр, ажил гүйлгээ, үйл явдал буюу дэлгэж харуулаагүй зүйл үгүй байх”.
- Тохиолдсон байх: “байгууллагад хамаатай ажил гүйлгээ, үйл явдал тухайн хугацаанд тохиолдсон байх”.
- Үнэн зөв байдал: “ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль тогтоомж болон холбогдох хууль тогтоомжоор олгогдсон эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журамд нийцэж байх”

12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад материаллаг бус залруулагдаагүй алдааг 2017 оны эхний улирлын санхүүгийн тайланд залруулга хийх зөвлөмж өгсөн болно.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

ТУЗ нь алдагдалтай зорилтот түвшин баталж өгсөн. Анхаарал татахуйц бусад чухал асуудал үгүй байна.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тус компанийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Дулааны 2 дугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2016 оны жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 419.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс аудитын явцад 336.8 сая төгрөг нь бараа материал, хөрөнгө, зардлын тооцооны болон худалдан авах ажиллагааны гэрээний зөрчлийн баримтын бүрдлийг хангуулан засаж, зөвлөмж өгч ажиллалаа. Тус компанийн материаллаг байдлын түвшинг нийт зардлын 1 хувиар буюу 167,2 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд илэрсэн алдаа зөрчлөөс явцын дунд зассан зөрчлийг хасахад 83,1 сая төгрөгийн залруулагдаагүй алдаан нь материаллаг байдлын түвшинд байгаа тул **зөрчилгүй** санал дүгнэлт өгөх санал оруулж байна.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2015 оны Санхүүгийн тайланд хийсэн аудитыг “Дундманхайдай-Аудит” ХХК –ны захирал Ж.Бямбажав, аудитор Н.Уртнасан, Д.Төмөрбаатар аудиторын туслах С.Ариунтунгалаг тус тус хэрэгжүүлсэн байна. 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 8 зөвлөмж өгснөөс 7 зөвлөмж хэрэгжүүлэн, 2 зөвлөмж дутуу биелэлттэй байна. Үүнд:

1. "Аморе интернейшнл" ХХК-тай тооцоо нийлж, өр барагдуулах ажлыг шуурхайлах

- Өмнөх оны авлагын тооцоог дахин хянаж баталгаажуулахын зэрэгцээ, 5-р зуухыг эрчим хүчний горимд шилжүүлэхтэй холбоотой гарсан бүх зардлыг нарийвчлан тооцож, он дуусахаас өмнө "Аморе интернейшнл" ХХК-тай тооцоо нийлж, гүйцэт төлүүлэх авлага барагдуулаагүй.

2. Худалдан авалтын журмыг зөрчихгүй байх

- Оны эхэнд батлагдсан төсөв, төлөвлөгөө санхүүжилтийн эх үүсвэрийг үндэслэн тендерийн журмаар худалдаж авах бараа, ажил үйлчилгээний хэмжээг тогтоох. Тендер зарлах, шалгаруулах, шалгарсан байгууллагуудтай гэрээ байгуулахдаа холбогдох хууль, журмыг зөрчихгүй байх

3. Үндсэн хөрөнгийн бүртгэлийн тухай

- Тус компанийн ажилтан Д.Пүрэв, Ц.Батбаатар нарт 2005 онд олгосон орон сууцны хөнгөлөлт болох 23.0 сая төгрөгийг Дулааны 2 дугаар цахилгаан станц ТӨХК-ны үндсэн хөрөнгийн дансанд /1.6 сая төгрөгийн элэгдэл байгуулсан 21.4 сая төгрөгийн үлдэгдэл өртгийн бүртгэлтэй/ орон сууц гэж бүртгэсэн нь байгууллагын өөрийн эзэмшилд байхгүй байна

17. Зөвлөмж

Зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

18. Зөрчилгүй санал дүгнэлт

Дулааны 2 дугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайланг хавсаргав

**“Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн
2016 оны санхүүгийн тайлан**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Авлагын талаар

Асуудал 2

Хөрөнгө оруулалт, худалдан авах
ажиллагааны талаар

Асуудал 3

Түрээсийн төлбөрийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1

Бараа материалын талаар

Менежментийн захидал

“ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ” ХХК аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Дулааны 2 дугаар цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлага, санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1

Авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

“Аморе интернэшнл” ХХК-аас авах авлага зохих хэмжээгээр барагдуулсан ч 2012 оны ДЭХ-ний 22,721.2 мянган төгрөг, 2014 оны ажлын хөлс материалын 55,575.7 мянган төгрөгийн авлагууд барагдуулаагүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуй нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ”, гэсэн заалттай нийцээгүй бөгөөд “ иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэлүүд

-Байгууллагын үйл ажиллагаанд хууль, эрх зүйн актууд зөрчигдөх, санхүүгийн тайлан гүйцэтгэлийн үр дүн буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

ҮАГ-ын зөвлөмж

Аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан гэрээнд заагдсан ажил үйлчилгээний өртөг, зардлыг бодитой тооцож, гэрээний хугацаа дуусгавар болсон үед нь гэрээний биелэлтийг тооцож байх, биелэлтийг 2017 оны 06 сарын 01-ний дотор ҮАГ-т ирүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитийн зөвлөмжийг хүлээн авч, холбогдох арга хэмжээг зохион байгуулан хариуг танилцуулна

Асуудал 2

Хөрөнгө оруулалт, худалдан авах
ажиллагааны талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

2016 оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн үр дүнд хийсэн ажлын хүрээнд үндсэн тоноглолын их засвар, үйлчилгээ, худгийн барилгын болон холболтын ажил, автомашин худалдан авах нийт 4 ажлыг гүйцэтгүүлэхдээ Эрчим хүчний яам болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төсөвт өртгийг хэтрүүлсэн 3 ажлын 211,645,9 мянган төгрөгийн, техникийн тодорхойлолт үнийн санал авах баримтгүй, дүгнэлт, протоколгүй 1 ажлын 11,700,0 мянган төгрөгийн ажлуудын төлбөрийг гүйцэтгэсэн зөрчил гаргасан байна Энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн " төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө"

-4 дүгээр зүйлийн 4.1.2.50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд захиалагч байна.

-46 дугаар зүйлийн 46.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараах эрх, үүрэгтэй байна:

-46.1.4.худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;

-46.1.6.бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих;

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Байгууллагын хэрэгцээт хөрөнгө материал бүрэн нийлүүлэгдэхгүй байх, хэрэгцээ шаардлага оновчгүй төлөвлөгдөх, хууль тогтоомж зөрчигдөх нөхцөл үүсэх эрсдэлтэй

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Байгууллагын зорилтот түвшин, хөрөнгө оруулалт,бараа ажил үйлчилгээг худалдан авах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх. биелэлтийг 2017 оны 06 сарын 01-ний дотор ҮАГ-т ирүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитийн зөвлөмжийг хүлээн авч,холбогдох арга хэмжээг зохион байгуулан хариуг танилцуулна

ҮАГ-ын ажиглалт

Байгууллагын дансанд бүртгэлтэй хөдлөх буюу үл хөдлөх хөрөнгө түрээслүүлсний орлогын тодорхой хувийг төсөвт төвлөрүүлээгүй Пүүний буюу хөрөнгийн орлогын 24 072 163.27 төгрөгнөөс ТӨБЗГ-т төвлөрүүлэх 20 хувийн орлогыг шилжүүлээгүй зөрчил нь Монгол Улсын төрийн өмчийн хорооны тогтоол 2007 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 42 тоот тогтоолоор “Түрээсийн төлбөрийн доод үнэ, гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай”-ын 3.в “Төрийн өмчит хуулийн эдгээдийн санхүүгийн тайлан балансад бүртгэлтэй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг хуулийн этгээд, иргэдэд түрээслүүлснээс олсон орлогын 20 хувийг төрийн өмчийн хорооны төрийн сангийн дансанд сар бүр төвлөрүүлж, улирал, жилийн эцэст төрийн өмчийн хороотой тооцоо нийлж акт үйлдэж байх” гэж заасантай нийцэхгүй байна

Эрсдэлүүд

-Байгууллагын үйл ажиллагаанд хууль, эрх зүйн актууд зөрчигдөх, санхүүгийн тайлан орлого үр дүн буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

ҮАГ-ын зөвлөмж

Холбогдох тооцоог биечлэн баталгаажуулан 2017 оны эхний улиралд ТӨБЗГ-т 20 хувь буюу 4,814.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх биелэлтийг 2017 оны 06 сарын 01-ний дотор ҮАГ-т ирүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитийн зөвлөмжийг хүлээн авч, холбогдох арга хэмжээг зохион байгуулан хариуг танилцуулна

Бараа материалын талаар

ҮАГ-ын ажиглалт

Бараа материал 16 дэд дансны 14 дансны эхний үлдэгдэл болон зарим үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл зөрүүтэй, 14400, 14110, 14510-10 тоот данснаас 87500-59-0002 тоот дансанд 57,8 сая төгрөгийн зарлагдсан гүйлгээ нь дансны бичилтийг буруу бүртгэснээс байгууллагын үр дүнг бууруулсан нь санхүүгийн тайлангийн оршин байх, үнэн зөв байдал гэсэн аудитын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэлүүд

Зардлыг зөв ангилж бүртгэхгүй байх, татвар ногдох орлого буруу илэрхийлэгдэх татварын хууль тогтоомж зөрчигдөх

ҮАГ-ын зөвлөмж

Ерөнхий журналд харилцсан дансны бичилтийн залруулга хийлгэн санхүүгийн тайланд тусгасан. НББ-ийн хуулийн 13.1-д ” санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” заалтыг мөрдөн ажиллах, биелэлтийг 2017 оны 06 сарын 01-ний дотор ҮАГ-т ирүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч, хариу мэдэгдэнэ

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2016 оны С1	2016 оны С2
1.ХӨРӨНГӨ		
1.1 Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	252 399 332,26	326 238 551,52
Дансны авлага	848 504 626,78	445 055 032,01
Татварын авлага		
Бусад авлага	140 164 400,49	61 120 036,98
Бараа материал	527 998 802,13	851 245 367,89
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	82 271 297,93	87 697 730,99
Эргэлтийн хөрөнгийн дүн	1 851 338 459,59	1 771 356 719,39
1.2 Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	17 217 603 462,42	18 253 556 902,54
Биет бус хөрөнгө	23 260 833,37	19 373 860,89
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	17 240 864 295,79	18 272 930 763, 43
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	19 092 202 755.38	20 044 287 482,82
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1 Өр төлбөр		
Дансны өглөг	1 456 194 014.38	165 033 998,9
Татварын өглөг	76 762 376.99	9 185 923,09
НДШ-ийн өглөг		
Банкны богино хугацаат өр төлбөр	0.00	4 100 000,00
Бусад өглөг		
Урьдчилж орсон орлого	0.00	0.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1 532 956 391.37	178 319 921,99
Урт хугацаат зээл	660 876 923.92	638 868 689,40
Бусад урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	660 876 923.92	638 868 689,40
Өр төлбөрийн нийт дүн	2 193 833 315.29	817 188 661,39
2.2 Эзэмшигчдийн өмч		
Төрийн өмч	1 821 344 502,78	1 821 344 502,78
Хувийн өмч		
Хувьцаат капиталын дүн	1 821 344 502,78	1 821 344 502,78
Дахин үнэлгээний нэмэгдэл	9 766 405 528.66	11 195 450 723,35
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	6 976 191 040.00	6 976 191 040.00
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	(1 665 571 631.35)	(765 887 394,70)
Тайлант үеийн ашиг		473 212 493,78
Өмнөх үеийн ашиг	(1 665 571 631.35)	(1 239 099 888.48)
Эзэмшигчдийн өмчийн дүн	16 898 369 440.09	19 227 098 871.43
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	19 092 202 755.38	20 044 287 482.82

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2015 он	2016 он
Борлуулалтын цэвэр орлого	16 207 429 600.29	19 190 452 149.25
Борлуулалтын өртөг	15 837 602 805.50	16 716 009 615.29
Нийг ашиг (алдагдал)	369 826 794.79	2 474 442 533.96
Түрээсийн орлого	16 700 277.66	13 926 981.46
Хүүгийн орлого	11 377 772.75	26 407 839.96
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого	165 987 047.38	178 330 531.08
Борлуулалт, маркетингийн зардал		1 728 000.00
Ерөнхий удирдлагын зардал	170 835 835.02	1 975 085 998.82
Санхүүгийн зардал		15 306 966.35
Бусад зардал		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз	11 141.63	38 441.18
Үндсэн хөрөнгө данснаас хассны олз, гарз	(18 202 267.90)	(1 884 486.10)
Биет бус хөрөнгө данснаас хассны олз, гарз		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз, гарз		
Бусад ашиг, алдагдал	(186 670 163.10)	(223 290 598.59)
Олз, гарзын дүн	(204 861 289. 37)	(225 136 643. 51)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	188 194 768.19	475 853 277.78
Орлогын татварын зардал	19 007 993.90	2 640 784. 00
Татварын дараах ашиг (алдагдал)	169 186 774.29	473 212 493.78
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг, алдагдал		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	169 186 774.29	473 212 493.78
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз, гарз		
Орлогын нийт дүн		
Нэгж хувыцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг, алдагдал	Нийт дүн
2014 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,821,344,502.78	10,004,175.759.66		(2,072,528,636.64)	9,752,991,625.80
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				237,770,231.00	237,770,231.00
Залруулсан үлдэгдэл	1,821,344,502.78	10,004,175.759.66		(1,834,758,405.64)	9,990,761,856.80
Тайлант оны ашиг, (алдагдал)				169,186,774.29	169,186,774.29
Өмчид гаргасан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг			6,976,191,040.00		6,976,191,040.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(237,770,231.00)			(237,770,231.00)
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,821,344,502.78	9,766,405,528.66	6,976,191,040.00	(1,665,571,631.35)	16,898,369,440.09
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				426 471 742.87	426 471 742.87
Залруулсан үлдэгдэл	1,821,344,502.78	9,766,405,528.66	6,976,191,040.00	(1,239,099,888.48)	17,324,841,182.96
Тайлант оны ашиг, (алдагдал)				473 212 493.78	473 212 493.78
Ногдол ашиг					
Өмчид гаргасан өөрчлөлт					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		1 429 045 194.69			1 429 045 194.69
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,821,344,502.78	11 195 450 723.35	6,976,191,040.00	(765 887 394.70)	19 227 098 871.43

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	2015 он	2016 он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	17,073,926,110.33	20,293,716,449.63
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	16,706,045,925.81	19,990,407,192.38
Даатгалын нөхөн олговор	52,314,847.00	59,822,501.00
Татаас санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	315,565,337.52	243,486,756.25
Мөнгөн зарлагын дүн	15,472,114,664.39	19,924,107,671.49
Ажиллагсад төлсөн	4,247,762,956.15	5,005,300,344.23
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,118,592,210.01	1,279,464,125.78
Бараа, материал худалдан авахад төлсөн	961,287,798.17	1,419,755,341.88
Ашиглалтын зардалд төлсөн	655,745,200.34	1,040,966,920.81
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,439,053,335.00	8,760,284,871.70
Хүүний төлбөрт төлсөн	76,448,411.33	
Татварын байгууллагад төлсөн	1,511,750,745.93	1,918,213,739.10
Даатгалын төлбөрт төлсөн	3,231,011.00	4,622,629.00
Бусад мөнгөн зарлага	458,242,996.46	495,499,698.99
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,601,811,445.94	369,608,778.14
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	11,377,772.75	26,407,839.96
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Хүлээн авсан хүүгийн орлого	11,377,772.75	26,407,839.96
Мөнгөн зарлагын дүн	231,433,600.00	269,665,859.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	231,433,600.00	269,665,859.00
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(220,055,827.25)	(243,258,019.04)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	0.00	45,820.06
Зээл авсан, үнэт цаас худалдсан	0.00	45,820.06
Мөнгөн зарлагын дүн	1,453,089,561.74	52,557,359.90
Зээл, үнэт цаасны төлбөр	1,453,100,703.37	18,712,621.02
Төлсөн ноогдол ашиг		33,837,360.00
Бусад	-11,141.63	7378.88
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,453,089,561.74)	(52,511,539.84)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(71,333,943.05)	73,839,219.26
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	323,733,275.31	252,399,332.26
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	252,399,332.26	326,238,551.52

/Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно./